

БАТЛАВ. ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Л.ТӨМӨРБААТАР

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2011 ОНЫ АЖЛЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хавдар судлалын үндэсний төв (ХСҮТ)-ийн 2011 оны зорилтууд:

- Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх,
- Хорт хавдраас сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх ажлыг аймаг, дүүргийн түвшинд эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх,
- Хавдрын тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах,
- Ажиллагсдын нийгмийн зарим асуудлыг шийдвэрлэх.

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах тасаг, алба, хамтран ажиллах байгууллагууд	Гарах үр дүн
Нэг: ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ: Төлөвлөгөөнд Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр (ХБӨСХҮХ) ба Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр (ХХСХДХ)-ийн үйл ажиллагааг тусган хэрэгжүүлэх				
1	Хавдартай тэмцэх дэлхийн өдрийг тэмдэглэж, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагааг явуулах	2-р сард	Захиргаа ЭШСМА	ХБӨСХҮХ-ийг хэрэгжүүлэх ажил эрчимжинэ
2	Монгол улсын Засгийн газрын Хавдартай тэмцэх 14 хоногийн аянг зохион байгуулах	11-р сард	Захиргаа ЭШСМА	ХБӨСХҮХ-ийг хэрэгжүүлэх ажил эрчимжинэ
3	Хавдрын эсрэг үндэсний аян 2011-ийг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулах	Жилийн турш	Захиргаа ЭШСМА Нийт тасгийн эрхлэгч, эмч нар ХААН банк, МҮОНРТ	Хорт хавдрын эрт илрүүлэлт нэмэгдэж, урьдчилан сэргийлэлт сайжирна
4	Аймаг, дүүргийн хавдар судлалын кабинетуудын үйл ажиллагааг хянан үнэлж, болзолт уралдааны дагуу урамшуулах	Жилийн турш	Захиргаа ЭШСМА	Кабинетийн үйл ажиллагаа сайжирна

5	Нийгмийн эрүүл мэндийн төвөөс зохиогдох үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж ажиллах	Жилийн турш	ЭШСМА	Олон нийтийн хавдраас сэргийлэх, эрт илрүүлэх талаарх мэдлэг нэмэгдэнэ
6	Дэлхийн хөнгөвчлөх эмчилгээний өдөр"-ийг тэмдэглэх өдөрлөг зохион байгуулах	3-р улирал	Хөнгөвчлөх тусламж эмчилгээний тасаг	Өдөрлөг зохион байгуулагдсан байна
7	1, 2-р шатлалын эмнэлгүүдэд хөнгөвчлөх тусламж үйлчилгээг сурталчлан таниулах	Жилийн турш	Хөнгөвчлөх тусламж эмчилгээний тасаг Итгэл хавдаргүй монгол үндэсний сан	1, 2-р шатлалын эмнэлгүүдэд хөнгөвчлөх эмчилгээний талаарх ойлголт нэмэгдэнэ
8	Хөнгөвчлөх эмчилгээнд хамрагдагсдын бүртгэл мэдээллийг боловсронгуй болгох төсөл боловсруулж холбогдох газарт өргөн барих	Жилийн турш	Хөнгөвчлөх тусламж эмчилгээний тасаг ММСС	Төсөл боловсруулагдсан байна
9	Хорт хавдрын өвчлөл, нас баралтын 10 жилийн үзүүлэлтээр эмхэтгэл хэвлүүлэх	3-р улирал	ЭШСМА	Эмхэтгэл хэвлэгдсэн байна
10	Зарим төрөлжсөн нарийн мэргэжлийн болон хувийн хэвшлийн эмнэлэг, лабораториос мэдээлэгдэхгүй байгаа хорт хавдрын тохиолдлыг бүртгэлд хамруулах арга хэмжээг авах	Жилийн турш	ЭШСМА	Хорт хавдрын бүртгэл мэдээлэл сайжирна
БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ: Зонхилох байрлалын хавдрыг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх үр дүнтэй арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх.				
1	Дурангийн мэс заслын багийг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах	Жилийн турш	Мэс заслын клиник Зөвлөх поликлиник	Дурангийн мэс заслын оношлогоо, эмчилгээ сайжирна
2	Том хэмжээний хагалгааны үед артери, венийн даралт үзэж хянах, аутогемотрансфузийг хэрэглэх аргачлал боловсруулж, хэрэглэж эхлэх	Жилийн турш	Эрчимт эмчилгээний тасаг	Хагалгааны үеийн аюулгүй байдал сайжирна
3	Үйлчлүүлэгчдэд зориулсан зөвлөгөө, оношлогооны багц үйлчилгээг нэвтрүүлэх	Жилийн турш	Зөвлөх поликлиник	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь нэмэгдэнэ
4	Химийн ламинар боксыг бүрэн ашиглалтанд оруулах	2-р улирал	Захиргаа Хими эмчилгээний тасаг	Сувилагч нарын хөдөлмөр хамгаалал аюулгүй байдал сайжирна
5	Лабораторийн мэдээллийг цахим бүртгэлд оруулах		Нэгдсэн лаборатори ЭШСМА	Мэдээллийн сан өргөжинө
6	Тусламж үйлчилгээний хүрээнд шаардагдах эм, эмнэлгийн хэрэгслийн талаарх зааварчилгаа бүхий гарын авлага боловсруулах	2-р улиралд	Клиникийн эм зүйн алба	Эм, эмнэлгийн хэрэгслийн ашиглалт сайжирна
7	Умайн хүзүү, хөх, ходоодны хорт хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлтийн удирдамж, стандартыг боловсруулж батлуулах	1-3-р улиралд	ХСҮТ-ийн мэргэжлийн баг (Г.Навчаа)	Удирдамж, стандарт батлагдсан байна
8	Хорт хавдрын хөнгөвчлөх эмчилгээний эмнэл зүйн болон өвдөлтийн менежментийн удирдамжийг	Жилдээ	Хөнгөвчлөх тусламж эмчилгээний тасаг	2 удирдамж боловсруулагдсан байна

	боловсруулах		ММСС	
9	Хүүхдийн бөөрний хорт хавдрын оношлогоо эмчилгээний удирдамжийг боловсруулах	Жилдээ	ХСҮТ-ийн мэргэжлийн баг Туяа эмчилгээний тасаг	Хүүхдийн бөөрний хорт хавдрын оношлогоо, эмчилгээ сайжирна
10	Зонхилон тохиолдох хавдрын туяа эмчилгээний аргачлал боловсруулах	Жилдээ	Туяа эмчилгээний тасаг	Хорт хавдрын туяа эмчилгээний чанар сайжирна
11	Дотуур туяа эмчилгээнд шинээр нэвтрүүлсэн давсаг, шулуун гэдэсний тунг тооцоолох аргачлалыг батлуулах	2-р улирал	Туяа эмчилгээний тасаг	Умайн хүзүүний хавдрын туяа эмчилгээний дараа гарах хүндрэл багасна
12	Эсийн шинжилгээний удирдамж боловсруулах	Жилдээ	Нэгдсэн лаборатори Эмгэг судлалын төв	Эсийн шинжилгээний чанар дээшилнэ
13	Эмэгтэйчүүдийн хавдрын мэс заслын өмнөх ба дараах үеийн сувилахуйн удирдамж боловсруулах, үзүүлэх сургалт зохион байгуулах	Хагас жилд	Сувилахуйн алба Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг	Удирдамж боловсруулагдаж, сургалт зохион байгуулагдсан байна
14	Элэг цөсний хавдрын мэс заслын өмнөх болон дараахи үеийн сувилахуйн тусламжийн удирдамж боловсруулах	4,5-р сард	Сувилахуйн алба ЭЦНБМЗТ	Удирдамж боловсруулагдсан байна
15	“Хэвлий болон цээжний хөндийн мэс засалд хэрэглэгдэх стандарт багаж хэрэгслийн нэгдсэн атлас” –ыг гаргаж хэвлүүлэх	4-5 –р сард	Мэс заслын клиник (А.Болд, Я.Эрдэнэ-Очир, Д.Ягаан)	Мэс заслын тусламж үйлчилгээний чанар сайжирна
16	Химийн эмчилгээний зөвлөмжийг боловсруулах	1-3-р улиралд	Хими эмчилгээний тасаг	Хөдөө орон нутгийн эмч нарын хими эмчилгээ хийх чадвар нэмэгдэнэ
17	Хавдрын эсрэг үйлчилгээтэй хүнсний бүтээгдэхүүнээр хоол хийх гарын авлага боловсруулах	1-6- сард	ХҮҮ алба (Л.Баярмаа, Д.Намжилмаа, Б.Баасанжав)	Гарын авлага боловсруулагдсан байна
18	Элэг, цөс,нойр булчирхайн мэс заслын дараах зохистой хоолны шинэ жор, зөвлөмж боловсруулах	2,3-р улиралд	ЭЦНБМЗТ (Д.Намжилмаа) ШУТИС-Хүнс биотехнологийн сургууль	Зөвлөмж боловсруулагдсан байна
19	Хөнгөвчлөх эмчилгээний сургалтын гарын авлагыг боловсруулах	Жилдээ	Хөнгөвчлөх тусламж эмчилгээний тасаг ЭШСМА	Гарын авлага боловсруулагдсан байна
БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ: Хавдрын үр дүнтэй шилжүүлгийн тогтолцоог боловсронгуй болгож хэрэгжүүлэх				
1	Хавдрын тусламж үйлчилгээг аймаг дүүрэгт бэхжүүлэх, Эрүүл мэндийн сайдын 292 тоот тушаалын хэрэгжилтийг эрчимжүүлэх	Жилдээ	ЭШСМА	Эрчимжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулагдсан байна
БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ: Хорт хавдрын оношилгоо, эмчилгээнд анагаах ухааны орчин үеийн дэвшилтэт арга технологийг				

нэвтрүүлж, чадавхийг сайжруулах				
1	Хавдрын шинэ тохиолдлын менежментийг эмч нарын багаар шийддэг тогтолцоог хэвшүүлэх	Жилдээ	Захиргаа (Г.Навчаа) ЭТҮЧА	Хавдрын шинэ тохиолдлын менежмент сайжирна
2	“Уншигч клуб”-ын үйл ажиллагааг өргөжүүлэн тогтмолжуулж, судалгааны үр дүнгээр мэдээлэл өгдөг болох	Жилдээ	Мэс заслын клиник Мэс заслын бус клиник Зөвлөх поликлиник	Эмч нарын мэдлэг сайжирна
3	Дурангийн мэс заслын аргаар элэгний зүүн дэлбэн тайрах хагалгааг хийх	Жилийн турш	ЭЦНБМЗТ	Элэгний хавдрын мэс заслын эмчилгээний чанар сайжирна
4	Элэгний баруун үүдэн венийн судасны салааг бөглөх эмчилгээг хийх	Жилийн турш	ЭЦНБМЗТ	Элэгний хавдрын мэс заслын эмчилгээний чанар сайжирна
5	Дурангийн мэс заслын аргаар ходоодны дисталь хэсэг тайрах хагалгааг хийх	Жилийн турш	ЕМЗТ	Ходоодны хавдрын мэс заслын эмчилгээний чанар сайжирна
6	Цээжний хөндийн эрхтэнүүдийн мэс засалд дурангийн хагалгааг нэвтрүүлэх	Жилдээ	ЕМЗТ (Б.Ганзориг, А.Болд)	Цээжний хөндийн мэс заслын эмчилгээний чанар сайжирна
7	Бүдүүн гэдэсний стом тавих хагалгааг дурангаар хийх	Жилдээ	ЕМЗТ (Р.Ганбаатар)	Стом тавих аргачлал боловсронгуй болно
8	Хөхний хавдрын үед харуул булчирхай илрүүлэх аргын практик хэрэглээг хэвшүүлэх	Жилдээ	ЕМЗТ (Д.Ягаан)	Эрхтэн хадгалах мэс заслын хувь нэмэгдэнэ
9	Эмэгтэйчүүдийн зарим хавдрыг дурангийн мэс заслаар авах аргыг нэвтрүүлэх	Жилдээ	Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг	Эмэгтэйчүүдийн хавдрын мэс заслын эмчилгээний чанар сайжирна
10	Төвөнхийн уян дуранг ашиглан мэс ажилбар хийх ба толгой хүзүүний байрлалын хавдрын өргөтгөсөн мэс заслын дараахь нөхөн сэргээх бичил мэс заслыг хийх	Жилдээ	ТХМЗТ	Толгой хүзүүний байрлалын хавдрын мэс заслын эмчилгээний чанар сайжирна
11	Өнгөц байрлалтай арьсны хавдрын дотуур туяа эмчилгээнд аппликатор нэвтрүүлэх	2-р улиралд	Туяа эмчилгээний тасаг	Өвчтөний эдгэрэх хугацаа багасна
12	Задарсан хавдар, ил шархны цус алдалтыг формалинаар тогтоох эмчилгээний аргыг нэвтрүүлэх	4-р улиралд	Хөнгөвчлөх тусламж эмчилгээний тасаг (Ц.Гантуяа)	Аргачлалыг практикт нэвтрүүлсэн байна
13	Иммуногистохимийн аргачлалыг нэвтрүүлэх	Жилийн турш	Нэгдсэн лаборатори	Хорт хавдрын оношлогоо эмгэг судлалын түвшинд дээшилнэ
14	Нян судлалын практикт “API” систем нэвтрүүлэх	Жилдээ	Бактериологийн лаборатори	Нян судлалын ялган оношлогоо сайжирна
15	Эхоэндоскопийн оношлогооны аргыг практикт нэвтрүүлэх	Жилдээ	Зөвлөх поликлиник (Ж.Оюунчимэг)	Оношилгоо сайжирна
ХОЁР. ЭМ ЗҮЙ ДЭМЖИХ ҮЙЛЧИЛГЭЭ				
БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ -7: Үйлчлүүлэгчийн ая тухтай байдлыг хангах, ажиллагсадын ажиллах нөхцлийг сайжруулах.				
1	Олон улсын чанарын стандартыг зөвлөх поликлиникт	Жилдээ	ЭТҮЧА	Нөхцөл байдлын судалгаа

	хэрэгжүүлэх боломжийг судлах		Зөвлөх поликлиник	хийж, шаардлагатай бичиг баримт боловсрогдсон байна
2	Спиртэнд суурилсан гар халдваргүйтгэх бодисыг дотуур эмийн санд найруулан тасаг нэгжүүдийг тогтмол хангах	Жилийн турш	ЭШХСА Эмийн сан ЭТҮЧА	Халдвар хамгааллын байдал сайжирна
3	Галын аюулгүй байдлыг хангах үзүүлэлт сургалт зохион байгуулах	2-р улирал	Хангамж үйлчилгээ-ИТА Захиргаа НОБЕГ	Галын аюулаас сэргийлэх мэдлэг, чадвар нэмэгдэнэ
4	Хавдрын өвөрмөц эмчилгээний үед үүсэх гадаад төрхийн өөрчлөлтийг эргэн сэргээх	7 хоног бүр	Туяа эмчилгээний тасаг Эмэгтэйчүүдийн хавдартай тэмцэх сан -AVON	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж дээшилнэ
5	Туяа эмчилгээний үед эрүүл эрхтэнг хамгаалах блок цутгах зориулалтын тугалгыг авах	2-р улиралд	Захиргаа СЭЗА Туяа эмчилгээний тасаг	Өвчтөний эрүүл эрхтэний хамгаалалт сайжирч, хүндрэл багасна
6	Туяа эмчилгээнд хэрэглэх туслах хэрэгслүүдийг цөөн тоогоор хангах	1 улиралд	Туяа эмчилгээний тасаг ОУАЭА	Туяа эмчилгээний үр дүн сайжирна
ГУРАВ: ЗАН ҮЙЛИЙН ӨӨРЧЛӨЛТ БОЛОН ХАРИЛЦАА БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ: Иргэдэд ХСҮТ-ийн тусламж, үйлчилгээг ойлгуулж таниулах, сурталчлах үйл ажиллагааг зохион байгуулах				
1	“Сувилагчийн нэг өдөр” өдөрлөгийг сард 2 удаа зохион байгуулах	Сард 2 удаа	Сувилахуйн алба	Үйлчлүүлэгчдийн хавдрын талаарх мэдлэг дээшилнэ
2	“Зөв зохистой хооллолтоор хавдраас сэргийлэх боломжтой” өдөрлөгийг зохион байгуулах	2, 11-р сар	ЭШСМА ХҮҮА	Өдөрлөг зохион байгуулагдсан байна
3	Хэвтэн эмчлүүлэгчид болон тэдгээрийн ар гэрийнхэнд эмчилгээний хоол хийх аргачлал, технологийг сурталчилж, өдөрлөг зохион байгуулах	Улиралд нэг удаа	ХҮҮА “Судалт ертөнц” ТББ	Үйлчлүүлэгчдийн мэдлэг дээшилнэ
4	Шинэ ба шинээр тархаж байгаа халдварт өвчний үед үзүүлэх тусламж үйлчилгээ сэдвээр үзүүлэх сургууль зохион байгуулах	Жилдээ	ЭТҮЧА ЭШХСА Сувилахуйн алба	Эмч ажилчид халдварын үед ажиллах туршлага нэмэгдэнэ
5	Хийгддэг шинжилгээний талаар үйлчлүүлэгчдэд зориулсан зөвлөмж боловсруулах	Жилдээ	Нэгдсэн лаборатори	Үйлчлүүлэгчдийн мэдлэг сайжирна
6	Туяа эмчилгээний талаар үйлчлүүлэгчдэд зориулсан зөвлөмжийг цувралаар гаргах	Жилдээ	Туяа эмчилгээний тасаг	Үйлчлүүлэгчдийн мэдлэг дээшилнэ
7	Хорт хавдартай хүүхдүүд, тэдний гэр бүлийнхэнд зөвлөгөө өгөх	Жилийн турш	Сэтгэл зүйч Нийгмийн ажилтан	Үйлчлүүлэгчдийн сэтгэл зүйн байдал сайжирна
8	Хагалгааны талаар ар гэрийнхэнд мэдээлэл өгөх цахим самбарын үйл ажиллагааг боловсронгуй болгох	1-р улирал	Эрчимт эмчилгээний тасаг	Ар гэрийнхэн мэдээлэл авах боломж бүрдэнэ
9	Цахим (web site) хуудасны мэдээллийг шинэчилж, сайжруулах	Жилийн турш	ЭШСМА Бусад тасаг, алба	Олон нийтэд хүрэх мэдээллийн хүртээмж, чанар нэмэгдэнэ

10	Химийн эмчилгээний талаар үйлчлүүлэгчдэд зориулсан сургалт явуулах, байгууллагын website-тад мэдээлэл байршуулах	1-4 улиралд	Хими эмчилгээний тасаг	Хими эмчилгээний талаархи олон нийтийн мэдлэг сайжирна
11	Хавдар судлал сэтгүүлийн олон нийтэд зориулсан дугаарыг гаргах	Жилдээ	ЭШСМА	Сэтгүүл хэвлэгдсэн байна
12	Хорт хавдрын мэдээллийн төвийг байгуулах үйл ажиллагааг жигдрүүлэх	Жилдээ	ЭШСМА ХҮ-ИТА	Төв байгуулагдсан байна
БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ: Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцааны соёл, зөвлөлгөө өгөх чадавхийг дээшлүүлэх				
1	Чанарын өдөрлөг зохион байгуулах	Хөтөлбөрийн дагуу	ЭТҮЧА Эм зүйн алба Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг	Өдөрлөг зохион байгуулагдсан байна
2	Эмч, эмнэлгийн дунд мэргэжилтнүүдэд ёс зүйн сургалтыг үе шаттай зохион байгуулах	Жилдээ	ЭТҮЧА	Сургалт зохион байгуулагдсан байна
3	Тамхигүй хамт олон болгоход чиглэсэн шаталсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Жилийн турш	Хүний нөөцийн алба ЭТҮЧА	3-аас доошгүй үйл ажиллагаа зохион байгуулсан байна
ТАВ. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ: ХСҮТ-ийн болон аймаг, дүүргийн хавдрын эмч, эмнэлгийн мэргэжилтний хүний нөөцийн удирдлага, төлөвлөлтийг сайжруулах, чадавхийг бэхжүүлэх				
1	Резидентурын сургалтыг зохион байгуулах	Жилийн турш	ЭШСМА	Хавдар судлаач эмчийн тоо нэмэгдэнэ
2	Хавдрын сувилагчийн мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах	Жилийн турш	ЭШСМА	Хавдрын сувилагчийн тоо нэмэгдэнэ
3	Төвийн хүний нөөцийн өнөөгийн байдалд судалгаа хийж, үр дүнг нь харгалзан, нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтнийг бэлтгэх бодлогод тусгах	Жилдээ	Хүний нөөцийн алба	Судалгаа хийгдэж, бодлогод туссан байна
4	Эмч, ажилчдын хөдөлмөрийн чадвар түр алдуулах өвчлөлийн байдалд судалгаа хийх	Жилдээ	Хүний нөөцийн алба СЭЗА	Эмч ажилчдын өвчлөлийн талаар мэдээлэлтэй болно
5	Эмч, сувилагч бусад мэргэжилтний багц цагийн биелэлтийг улирал бүр гаргаж жилээр нь тооцох	Улирал бүр	ЭШСМА	Багц цагийн биелүүлсэн мэргэжилтний тоо нэмэгдэнэ
6	ЗГХА-ЭМГ –ын Эмнэлгийн мэргэжлийн зөвшөөрлийн нэгдсэн бүртгэлд ХСҮТ-ийн мэргэжилтнүүдийн талаарх мэдээллийг оруулах	Жилийн турш	ЭШСМА	Мэргэжилтнүүдийн мэдээлэл орсон байна
7	Нийт ажиллагсдын гадаад хэл, компьютерийн мэдлэгийг дээшлүүлэх талаар сургалт зохион байгуулах	Жилдээ	Захиргаа ЭШСМА Хүний нөөцийн алба	Ажиллагчдын мэдлэг, чадвар сайжирна
8	Тоног төхөөрөмжийн ашиглалт засвар үйлчилгээний сургалтанд холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулах	Жилдээ	Хангамж үйлчилгээ-ИТА Хүний нөөцийн алба	Мэргэжилтний мэдлэг, чадвар сайжирна
9	Сувилагчдын дунд байгууллагын “Итгэмжит сувилагч” шалгаруулах ур чадварын шалгаруулалтыг зохион байгуулах	12-р сард	Сувилахуйн алба Хүний нөөцийн алба	Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар сайжирна
10	Хавдрын бүртгэл мэдээллийн бүртгэлийн шинэчилсэн маягтуудын талаар аймаг, дүүргийн мэргэжилтнүүдэд	3, 4 –р улиралд	ЭШСМА ММСС	Сургалтанд оролцогчдын мэдлэг дээшилнэ

	сургалт явуулах			
11	ICDO-3 номыг монгол хэл дээр орчуулах, зөвшөөрөл авах, хэвлүүлэх, аймаг, дүүргийн мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулах	3, 4 –р улиралд	ЭШСМА ММСС	Сургалтанд оролцогчдын мэдлэг дээшилнэ
12	Хөнгөвчлөх эмчилгээний сургалтыг дүүрэг, аймгийн нэгдсэн эмнэлгийн хавдрын болон хөнгөвчлөх эмчилгээний эмч, өрх сумын эмч нарт явуулах	3, 4 –р улиралд	Хөнгөвчлөх тусламж эмчилгээний тасаг ЭШСМА ММСС	Сургалтанд оролцогчдын мэдлэг дээшилнэ
13	“Эмэгтэйчүүдийн байрлалын хорт хавдрын орчин үеийн оношилгоо эмчилгээ” сэдэвт семинар зохион байгуулах	1-р улиралд	Эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг “Итгэл хавдаргүй Монгол” үндэсний сан	Орон нутгийн эх барих, эмэгтэйчүүдийн эмч нарын хавдрын талаархи мэдлэг дээшилнэ
14	Баруун болон Зүүн бүсийн аймгуудад хөнгөвчлөх эмчилгээний сургалтыг зохион явуулах	Жилдээ	Хөнгөвчлөх тусламж эмчилгээний тасаг Итгэл Хавдаргүй Монгол Үндэсний сан	Сургалт зохион байгуулагдсан байна
15	УБ хотын нэгдсэн эмнэлгүүд болон дүүргийн, өрхийн эмч нарт зориулж өвдөлт намдаах эмчилгээний талаар үечилсэн сургалт зохион байгуулах	Жилдээ	Хөнгөвчлөх тусламж эмчилгээний тасаг ЭШСМА	Сургалт зохион байгуулагдсан байна
16	Аймаг, дүүргийн хавдрын болон мэс заслын эмч нарт элэгний анхдагч өмөнгийн, үүнд хэт авиан оношлогооны талаарх сургалт зохион байгуулах	Жилдээ	ЭЦНБМЗТ ЭМЯ	Аймаг, дүүргийн хавдрын болон мэс заслын эмч нарын элэгний хавдрын талаархи мэдлэг, чадвар сайжирна
17	Эс зүйч эмч, техникч, лаборант сургах	Жилдээ	Нэгдсэн лаборатори ММСС Монголын Эд-Эс судлалын нийгэмлэг	Хорт хавдрын оношлогооны хугацаа богиносж, эрт үед илэрнэ
18	Аймаг, дүүргийн мэс засал, хавдар судлаач, эмэгтэйчүүдийн эмч нарт хөхний хорт хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлтийн талаар сургалт зохион байгуулах	7-8-р сард	ЕМЗТ ММСС	Сургалтанд оролцогчдын мэдлэг сайжирна
ЗУРГАА . ЭРҮҮЛ МЭНДИЙН САНХҮҮЖИЛТ БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ: Мэргэжлийн ур чадвар, мэдлэг хандлагатай уялдуулан цалин, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох				
1	Сувилагчдын дунд байгууллагын “Итгэмжит сувилагч” шалгаруулах ур чадварын шалгаруулалтыг зохион байгуулж, үр дүнг нь харгалзан урамшуулах	12-р сард	Сувилахуйн алба Хүний нөөцийн алба	Сувилахуйн тусламж үйлчилгээний чанар сайжирна
БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ: Төсвөөс гадна бусад санхүүжилтийн эх үүсвэрийг хайж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, Олон улсын түвшинд хүрсэн стандарт удирдамж, технологийг хэрэгжүүлэхтэй холбогдолтой зарцуулалтын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, санхүүжилтийг тооцох				
1	Төвийн хэмжээнд шаардлагатай байгаа оношлогоо, эмчилгээний тоног төхөөрөмжийн судалгааг шинэчлэн гаргах, 2011 онд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангамжийг тусгай төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх	1-2-р улиралд	ХҮ-ИТА	Судалгаа хийгдсэн байна

2	Эрүүл мэндийн салбарын эдийн засагч, нягтлан бодогч нарт үзүүлэх сургалт явуулах	1-р улиралд	Захиргаа СЭЗА	Сургалт явагдсан байна
3	Санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн ACOLOS программд удирдлагын бүртгэлийн бүрэлдэхүүнийг нэмж оруулах	Жилдээ	СЭЗА	Удирдлагад хүрэх санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл нэмэгдэнэ
4	Нэмэлт болон төлбөрт тусламж үйлчилгээний журмыг шинэчлэх	Жилийн турш	СЭЗА	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, орлогын дотоод бүртгэл мэдээлэл сайжирна
5	Төсвөөс бусад санхүүжилтийн эх үүсвэрээс хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжийг судалж хэрэгжүүлэх	Жилийн турш	СЭЗА Бусад тасаг алба	Хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна
6	Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг авах механизмыг боловсронгуй болгох	Жилийн турш	Захиргаа СЭЗА ЭШСМА	Эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг бүрэн авсан байна

БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ: Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг эрчимжүүлэх

1	Хорт хавдраар өвчлөгсдийн амьдрах чадварын судалгааг хийх	Жилийн турш	ЭШСМА	Судалгаа хийгдсэн байна
2	Эллипин эмийн клиникийн судалгаанд оролцох	Жилийн турш	ЭШСМА Монос групп	Судалгааны явцын тайлан гарсан байна
3	Хавдрын эмчилгээнд хэрэглэгдэж буй зарим химийн эмийн эмчилгээний үр дүнг судлах	Жилдээ	Хими эмчилгээний тасаг	Эмийн эмчилгээний үр дүн судлагдсан байна
4	Монголчуудын толгой хүзүүний хавдрын 10 жилийн өвчлөлд судалгаа хийх	Жилдээ	ТХМЗ	ЭШОП хуралд илтгэл тавьсан байна
5	Хавдрын сувилахуйн тусламжийн хөгжлийн байдал сэдэвт судлаач сувилагчдын онол практикийн хурал зохион байгуулах	4-р сард	Сувилахуйн алба ЭШСМА	ЭШОП хурал хийсэн байна
6	Хөх тайрах мэс заслын дараах сэргээн засах эмчилгээний үр дүнг тооцох судалгаа	Жилдээ	Зөвлөх поликлиник (Ц.Цэнгэлмаа)	Судалгаа хийгдсэн байна

БАЙГУУЛЛАГЫН СТРАТЕГИ: Гадаад харилцааг хөгжүүлэх бодлого хэрэгжилт

1	Олон улсын байгууллагуудтай холбоо тогтоож сувилахуйн мэргэжилтэн авах талаар санал боловсруулж судлах	Жилдээ	Сувилгааны алба	Санал боловсруулж, холбогдох байгууллагад хүсэлт гаргасан байна
2	“Хөнгөвчлөх тусламж үйлчилгээг улсын хэмжээнд хөгжүүлэх” төслийг хэрэгжүүлэх асуудлыг үргэлжлүүлэн судлах	Жилийн турш	Хөнгөвчлөх эмчилгээний тасаг (Ц.Гантуяа)	Төслийн асуудлаар харилцсан байна
3	Хөнгөвчлөх эмчилгээний орны дэргэдэх сургалтыг аймаг, дүүргийн хавдрын эмч нарт зохион байгуулах	Жилдээ	Хөнгөвчлөх эмчилгээний тасаг АНУ-ын Сан Диего Хоспис институт	Сургалт зохион байгуулагдсан байна

4	Эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслын чиглэлээр эмч мэргэжилтнүүдийг гадаадад сургалтанд хамруулах	Жилдээ	Захиргаа ЕМЗТ ЭЦНБМЗТ	Сургалтанд хамрагдсан байна
5	Хагалгааны дараахи судсаар болон гуурсаар хооллох талаар сургалт зохион байгуулах	Жилдээ	Эрчимт эмчилгээний тасаг Монголын судсаар болон гуурсаар хооллох нийгэмлэг Гадаадын аль нэг түнш байгууллага	Сургалт зохион байгуулагдсан байна
6	“Ходоодны хорт хавдрын мэс заслын орчин үеийн чиг хандлага” сэдэвт онол практикийн хурал зохион байгуулах	5-р сар	Мэс заслын клиник Тайваны их сургуулийн эмнэлэг	ЭШОП хурал хийсэн байна
7	Элэгний хорт хавдрын хими ба туяа эмчилгээний хамтарсан туршилт судалгааны чиглэлээр сургалт зохион байгуулах	1-р улиралд	Хими эмчилгээний тасаг ЭШСМА Ази–Номхон далайн Элэгний хавдар судлалын баг	Сургалт зохион байгуулагдсан байна
Нэг: Тасаг албадаас хавдар судлалын алба байгуулагдсаны 50 жилийн ойг угтсан аяны хүрээнд хийх ажил				
1	ХСҮТ байгуулагдсаны 50 жилийн ойн арга хэмжээг угтсан болон тэмдэглэн өнгөрүүлэх үйл ажиллагааг тусгай төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх	Жилийн турш	Нийт хамт олон	Үйл ажиллагаа тусгай төлөвлөгөөний дагуу хийгдсэн байна
Товчлолын тайлбар: ЕМЗТ Ерөнхий мэс заслын тасаг ЗГХА-ЭМГ Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газар МҮОНРТ Монголын үндэсний олон нийтийн радио телевиз ММСС Монголын Мянганы сорилтын сан НОБЕГ Нийслэлийн онцгой байдлын ерөнхий газар ОУАЭА Олон улсын атомийн энергийн агентлаг ХСҮТ Хавдар судлалын үндэсний төв ХБӨСХҮХ Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр ХХСХДХ Хорт хавдраас сэргийлэх, хянах дэд хөтөлбөр ХҮ-ИТА Хангамж үйлчилгээ, инженер техникийн алба ХҮҮА Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний алба СЭЗА Санхүү эдийн засгийн алба ТББ Төрийн бус байгууллага ТХМЗТ Толгой хүзүүний мэс заслын тасаг ШУТИС Шинжлэх ухаан техникийн их сургууль ЭМЯ Эрүүл мэндийн яам ЭЦНБМЗТ Элэг, цөс, нойр булчирхайн мэс заслын тасаг ЭТҮЧА Эмнэлгийн тусламж үйлчилгээ, чанарын алба ЭШХСА Эмнэлгээс шалтгаалах халдвараас сэргийлэх алба ЭШОП Эрдэм шинжилгээ, онол практик ЭШСМА Эрдэм шинжилгээ, сургалт мэдээллийн алба				

Тайлбар: Дараах үйл ажиллагааг тусгай төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Хавдрын эсрэг үндэсний аян 2011,
2. Хавдар судлалын алба үүсэн байгуулагдсаны 50 жилийн ойг угтах,
3. Байгууллагын 2011 оны их засвар,
4. Байгууллагад 2011 онд шаардагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангамж.

Хянасан:

Клиник эрхэлсэн дэд захирал

Эрдэм шинжилгээ, сургалт эрхэлсэн дэд захирал

Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал

Г.Навчаа

Г.Пүрэвсүрэн

О.Баяр